

МОНГОЛЫН ЗОХИОЛЧ, ХӨГЖМИЙН ЗОХИОЛЧ, НИЙТЛЭГЧДИЙН НИЙГЭМЛЭГИЙН ДҮРЭМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Албан ёсны нэр:

Монголын Зохиолч, Хөгжмийн зохиолч, Нийтлэгчдийн нийгэмлэг /цаашид нийгэмлэг гэх/

Товчлол нь: МЗХНН

Нэрийн орчуулга: Mongolian Society of Composers, Authors & Publishers

Товчлол нь: MOSCAP

Байршил:

Нийгэмлэг нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байх бөгөөд өөрийн салбараа бусад хот, орон нутагт Удирдах зөвлөлийн шийдвэрээр нээн ажиллуулж болно.

- 1.1. Нийгэмлэг нь “Зохиогчийн эрхийн тухай хууль”-ийн хүрээнд хөгжмийн үгтэй болон үггүй бүтээлийн эрх эзэмшигчийн амины ба эд хөрөнгийн онцгой эрхийг Монгол улс болон гадаад улсад, гадаад улсын хөгжмийн бүтээлийг Монгол улсад харилцан төлөөлөн хэрэгжүүлэх эрхэм зорилго бүхий хөгжмийн зохиолч, зохиолч, дууны үг ая зохиогч, хөгжмийн найруулагч, хөгжмийн нийтлэгч (music publisher), зохиогчийн эрх эзэмшигчид, (өв залгамжлагч, эрх шилжүүлэн авсан хувь хүн хуулийн этгээд)-ийг эгнээндээ нэгтгэсэн, гишүүддээ үйлчилдэг Хамтын удирдлагын байгууллага мөн.
- 1.2. Нийгэмлэг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээр болон тэдгээртэй нийцүүлж гаргасан бусад хууль тогтоомж, дүрэм журам, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.
- 1.3. Нийгэмлэг нь гишүүдийнхээ бүтээлийг ашиглах онцгой эрхийг төлөөлөн хэрэгжүүлэхдээ хөгжим, уран зохиол, дүрслэх урлаг, тайзны урлаг, аудио визуал дэлгэцийн урлагийн төрөлжсөн мэргэжлийн ТББ, Оюуны өмчийн газар, Олон улсын зохиолч, хөгжмийн зохиолчдын нийгэмлэгүүдийн холбоо /CISAC/, Дэлхийн Оюуны Өмчийн байгууллага /WIPO/-той хамтран ажиллана.
- 1.4. Нийгэмлэг нь үйл ажиллагаандаа лого, тамга, тэмдэг, албан бланк хэрэглэнэ.
- 1.5. Албан ёсны зөвшөөрөл бүхий хэвлэл, сонин сэтгүүл, вэб хуудастай байж болно.
- 1.6. Олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадад салбар, төлөөлөгчийн газар байгуулах асуудлыг тухайн улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.
- 1.7. Салбар төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй бөгөөд Нийгэмлэгээс баталсан журмын дагуу түүний нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

Хоёр. ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Нийгэмлэгийн үндсэн зорилго:

- 2.1.1. Зохиогчийн эрхэд хамаарах бүтээл ашиглах онцгой эрх, ашиг сонирхлыг Монгол улсад болон гадаад улсад хууль ёсоор төлөөлж хэрэгжүүлэх, хяналт тавих төдийгүй олон улсын зохиогчдын бүтээлийн эрхийг Монгол улсад харилцан төлөөлнө.
- 2.1.2. Зохиогчийн эрхэд хамаарах хууль тогтоомж, дүрэм журмыг боловсронгуй болгоход санал өгөх, дэмжих, хэрэгжүүлэх болон оюуны өмчийг дээдлэх соёлыг хэрэглэгчдэд төлөвшүүлэх замаар Монголын дуу хөгжмийн урлагийн хөгжилд хувь нэмэр оруулна.
- 2.1.3. Зах зээлийн болон технологийн хөгжлийн өөрчлөлтөд тасралтгүй дасан зохицож, хамтын удирдлагын шилдэг туршлагыг нэвтрүүлэхийг эрмэлзэнэ.

2.2. Нийгэмлэгийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 2.2.1. Нийгэмлэгийн үндсэн үйл ажиллагаа нь зохиогч, зохиогчийн эрх эзэмшигчийн төлөөлөх эрх олгох зөвшөөрлийг авч гишүүнчлэлдээ хамруулж, гишүүдийнхээ бүтээлийн амины ба эд хөрөнгийн онцгой эрхийг Монгол болон гадаад улс оронд хэрэгжүүлэх, олон улсын хөгжмийн нийгэмлэгүүдтэй харилцан төлөөлөх гэрээ байгуулж, гадаад хөгжмийн бүтээлийг Монгол улсад ашиглах эрхийг харилцан хамгаалахад чиглэгдэнэ.
- 2.2.2. Хөгжмийн бүх төрлийн бүтээлийн нийтийн гүйцэтгэлийн ба механик эрхийг хэрэгжүүлж, хуулийн хүрээнд лицензийн гэрээгээр бүтээлийг олон нийтэд тоглуулах, олон нийтэд дамжуулах, хуулбарлах, түрээслүүлэх, нийтэд түгээх, хэвлэх, нийтлэх, нийтийн хүртээл болгох зэргээр бүтээл ашиглуулж, бүтээл ашиглалтын төлбөрийг хэрэглэгчдээс цуглуулж, төлбөр хуваарилах журмын дагуу гишүүддээ хуваарилна.
- 2.2.3. Нийгэмлэгийн удирдлагад байгаа хөгжмийн бүтээлийг ашиглах талаар ашиглагчтай лицензийн гэрээ байгуулах, ашиглах зөвшөөрөл олгох болон ашигласны төлбөрийг хураан авах гэрээнд бүтээлийг ашиглах хэлбэр, хугацаа, хэмжээ, бүтээл ашигласны төлбөрийн хураамж авах, төлбөр тооцоо хийх, гишүүдийн хөгжмийн бүтээлд хамаарах зохиогчийн эрхийг ашигласнаас үүдэн гарах хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчлийг арилгах, эдгээртэй хамаарах аливаа санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөх аргаар шийдвэрлэх, эсвэл хууль, хяналтын байгууллагад хандах зэрэг эрх зүйн харилцаатай холбоотой асуудлыг тусгасан байна.
- 2.2.4. Монгол Улс болон гадаад улс оронд болох хурал, цуглаан, чуулганд болон гишүүдийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд Нийгэмлэгийг төлөөлж оролцож болно.
- 2.2.5. Гишүүд зохиогчийн эрхээ олон улсад бүртгүүлэх, олон улсын эрхийн хамгаалалтын хүсэлт гаргахад дэмжлэг үзүүлэх.
- 2.2.6. Нийгэмлэг нь Зохиогчийн эрхийн хамтын удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор хөгжмийн бүтээлийг бүртгэх, холбогдох мэдээллийг цуглуулах; гишүүдийнхээ зохиогчийн эрх болон уран бүтээлийн эрхийн удирдлагатай холбоотой иж бүрэн мэдээллийг цуглуулж, бүртгэн баримтжуулан, олон улсын стандартын дагуу мэдээллийн сан бүрдүүлнэ.
- 2.2.7. Бүтээл ашигласны төлбөрийн хэмжээ тарифыг гишүүдийн оролцоотой тогтоож, оюуны өмчийн газраар хянан баталгаажуулах, бүтээл ашиглагчаас нөхөн олж авах, шаардлагатай тохиолдолд зуучлагчдыг томилон гэрээгээр ажиллуулах,
- 2.2.8. Бүтээл ашиглаж буй иргэн, хуулийн этгээдийн санхүүгийн тайлан тэнцлийг хууль хяналт, аудитын байгууллагаар шалгуулах, мэдээлэл авах,
- 2.2.9. Ижил төстэй зорилготой гадаадын компани, нийгэмлэгүүдтэй гишүүдийн эрх ашгийг хамгаалж хэрэгжүүлэх зорилгоор харилцан төлөөлөх гэрээ, хэлэлцээр байгуулах, олон улсын холбоонд нэгдэн орох, үйл ажиллагаанд нь оролцох,
- 2.2.10. Нийгэмлэгийн ашиг сонирхлыг хамгаалах, хууль тогтоомжийг дэмжих, эсэргүүцэх зэрэг тусгай зорилгод хөрөнгө шаардагдах тохиолдолд гишүүдээс хандив цуглуулах,
- 2.2.11. Дүрэмд заасан заалтуудыг хэрэгжүүлэх тусгай журам баталж, үйл ажиллагаандаа мөрдөнө.

Гурав. НИЙГЭМЛЭГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

3.1. Нийгэмлэгийн гишүүнчлэл

- 3.1.1. Нийгэмлэгийн зорилго, үйл ажиллагааны чиглэл, дүрэм, зохиогчийн эрхийг төлөөлөх гэрээний нөхцлүүд, бүтээл ашиглалтын тариф ба лицензийн орлого хуваарилах журмыг хүлээн зөвшөөрч дэмжсэн дотоод гадаадын уран бүтээлчид, иргэн, байгууллага нийгэмлэгт гишүүнээр элсч болно.
- 3.1.2. Гишүүн элсэх өргөдлөө Удирдах зөвлөлийн хурлаас батлагдсан маягтын дагуу бичгээр гаргана.
- 3.1.3. Өргөдлийг нийгэмлэгийн гэрээ эрхийн асуудал хариуцсан ажилтан хүлээн авч, бүртгэн, зохиогчийн эрх эзэмшигчийн төлөөлөх эрх олгох гэрээ хийж, гишүүнээр элсүүлэх асуудлыг удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлж, бүтээлийн мэдүүлэг жагсаалтыг бүртгэл мэдээллийн санд бүртгэнэ.
- 3.1.4. Гишүүн нас барсан тохиолдолд түүний гэрээслэлээр буюу хууль ёсны өв залгамжлагч нь нийгэмлэгийн гишүүн болох эрхтэй. Гишүүн нас барсан оноос хойш гурван жил өнгөрсний дараа түүний өв залгамжлагч тогтоогдоогүй бол гишүүний эрхийг цуцална.

3.1.5. Нийгэмлэгийн гишүүн дараах эрх үүргийг хэрэгжүүлнэ.

а/ “Зохиогчийн эрхийн тухай хууль”-д заасны дагуу зохиогчийн эрх эзэмшигчийн төлөөлөх эрх олгох зөвшөөрлийн гэрээгээр Нийгэмлэгт бүтээл ашиглуулах онцгой эрхээ төлөөлүүлэх бөгөөд гишүүнчлэлийн гэрээний хүчинтэй хугацаанд гэрээний эрх үүргээ 3.1.8-д зааснаас бусад нөхцөлд өөр этгээдэд шилжүүлэхгүй.

б/ Бүтээл ашиглуулах лицензийн гэрээг гуравдагч этгээдтэй байгуулсан болон бүтээл ашиглах онцгой эрхээ бусдад бүрэн ба хэсэгчлэн шилжүүлсэн бол нийгэмлэгт нэн даруй мэдээлэх,

в/ Жил бүр бүх гишүүдийн хуралдаа идэвхтэй оролцож, нийгэмлэгийн шийдвэрийг дагаж мөрдөх, зохиогчийн эрх эзэмшигчийн төлөөлөх эрх олгох зөвшөөрлийн гэрээ, бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээ, лицензийн төлбөр цуглуулах хуваарилах журамд саналаа өгөх, г/Гишүүн одоо байгаа болон ирээдүйд туурвих хөгжмийн бүтээлээ нийгэмлэгт бүртгүүлэх үүрэгтэй ба бүтээлийн жагсаалтын өөрчлөлт шинэчлэлтийг жил бүр болон тухай бүр өгч, бүтээлээ ашиглуулсны төлбөрийг нийгэмлэгийн хуваарилалтын журамд заасны дагуу авах, д/ Удирдах зөвлөлөөс тухайн жилд баталсан гишүүнчлэлийн жилийн төлбөр ба элсэлт бүртгэлийн хураамж төлөх,

е/ Бүтээл ашигласны төлбөр хуваарилалтын талаарх санал гомдлоо Хяналтын зөвлөлд гаргаж, шалгуулах,

ё/ Нийгэмлэгийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, бүтээл ашиглалтын батлагдсан тариф, төлбөр хуваарилалтын журам, өөрийн бүтээлийн ашиглалтын талаарх мэдээллийг шаардаж танилцах эрхтэй ба бусад гишүүний зөвшөөрөлгүй бусад гишүүний төлбөр хуваарилалтыг харах эрхгүй

ж/ Нийгэмлэгийн удирдах зөвлөлийн дарга ба гишүүдийг сонгох, сонгогдох санал өгөх, нийгэмлэгийн үйл ажиллагааны талаар санал гаргах, хяналт тавих, гишүүнчлэлээс татгалзах эрхтэй.

з/ Гишүүнчлэлээс татгалзах хүсэлтээ өөрөө бичгээр гаргасан тохиолдолд гишүүний эрхийг цуцалж, хүсэлт гаргаснаас 6 сарын дараа эрх ашгийг дуусгавар болгоно. Гишүүний эрх цуцлагдсанаас 6 сарын хугацаанд бүтээл ашиглалтын тайланд үндэслэн өөрийн бүтээл ашиглалтын төлбөрөө авах эрхтэй. 6 сараас хойших хугацааны бүтээл ашигласны орлогыг нийгэмлэгийн “Нөөц сан”-д төвлөрүүлнэ. Нөөц сангийн зарцуулалтыг хуваарилалтын журмаар зохицуулна.

И/ Өөрийн бүтээлийг хууль бусаар ашиглаж байгаа талаарх мэдээлэлийг баримтжуулан өгч, хуульд заасны дагуу арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах

Й/ Нийгэмлэгийн дүрэм, ерөнхий чуулган, бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоол шийдвэрийг дагаж мөрдөх ба нийгэмлэгийн нэр хүнд болон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

3.2. Нийгэмлэгийн эрх барих дээд байгууллага

3.2.1. Нийгэмлэгийн эрх барих дээд байгууллага нь Ерөнхий чуулган байна.

3.2.2. Ерөнхий чуулганыг 4 жилд 1 удаа зохион байгуулна.

3.2.3. Ерөнхий чуулганаар дараах асуудлыг хэлэлцэнэ:

а/ Нийгэмлэгийн зорилго, хөгжлийн стратеги, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох

б/ Нийгэмлэгийн дүрмийг хэлэлцэж батлах

в/ Удирдах зөвлөлийн даргын ажлын тайланг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөх

г/ Хяналтын зөвлөлийн тайланг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөх,

д/ Удирдах зөвлөлийн дарга, гишүүд, орлогч гишүүдийг сонгох, чөлөөлөх,

е/ Хяналтын зөвлөлийн гишүүд, орлогч гишүүдийг сонгох, чөлөөлөх,

ё/ Нийгэмлэгийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хэлэлцэх

Ж/ Байгууллагын нэр өөрчлөх асуудлыг шийдвэрлэх

3.2.4. Ерөнхий чуулган ба жил бүрийн бүх гишүүдийн хурлын зарыг 21 хоногийн өмнө хүргэнэ. Зарлалд болох газар, огноо, цаг, хэлэлцэх асуудлыг мэдээлсэн байна.

3.2.5. Гишүүнд зар хүрээгүй нь Ерөнхий чуулган ба Бүх гишүүдийн хурлаас гарах тогтоол шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

3.2.6. Ерөнхий чуулганы төлөөлөгчдийг сонгох журмыг Удирдах зөвлөл боловсруулж батлана.

- 3.2.7. Ээлжит бус Ерөнхий чуулганыг Бүх гишүүдийн саналыг үндэслэн Удирдах зөвлөлийн гишүүдийн 3/2 оос доошгүй хувийн саналаар зарлан хуралдуулж болно.
- 3.2.8. Жил бүрийн Бүх гишүүдийн хурлыг Удирдах зөвлөл оны сүүлийн 2 сард багтаан эсвэл дараа жилийн эхний 2 сард багтаан товлон, цахимаар ба холимог хэлбэрээр хуралдуулна. Бүх гишүүдийн хурлын хоорондын хугацаа 15 сараас илүүгүй байна.
- 3.2.9. Жил бүрийн Бүх гишүүдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ.
- А/ Нийгэмлэгийн жил бүрийн үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагааны зардалд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээг хэлэлцэх
 Б/ Бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээг эцэслэн батлах
 в/ Бүтээл ашигласны төлбөр хураан авах, хуваарилах журмын өөрчлөлтийг эцэслэн батлах
 г/ Эрх эзэмшигчийн төлөөлөх эрх олгох зөвшөөрөл буюу гишүүнчлэлийн гэрээг хэлэлцэн батлах
- 3.2.10. Ээлжит бус Бүх гишүүдийн хурлыг Удирдах зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар тухай бүр зарлан хуралдуулж болно.
- 3.2.11. Бүх гишүүдийн хуралд оролцох боломжгүй гишүүн хэлэлцэх батлах асуудлаар саналаа бичгээр эсвэл цахим хэлбэрээр ирүүлэх, эсвэл хурлын даргад саналын эрхээ хурал эхлэхээс өмнө шилжүүлж болно.
- 3.2.12. Ерөнхий чуулган ба Бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, тогтоол шийдвэрийг гишүүдэд 45 хоногийн дотор цахимаар илгээж архивлан хадгална.

3.3. Удирдах зөвлөл

- 3.3.1. Удирдах зөвлөл нь Нийгэмлэгийн үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангаж ажиллана.
- 3.3.2. Удирдах зөвлөл нь 15 хүний бүрэлдэхүүнтэй байна. Удирдах зөвлөлийн гишүүдийн 50 хүртэлх хувьтай тэнцэх орлогч гишүүнийг нэмж сонгож болно. Жинхэнэ гишүүн орон гарсан тохиолдолд орлогч гишүүн 30 хоногийн дотор нөхөн сонгогдоно.
- 3.3.3. Удирдах зөвлөлийн гишүүдийн 6 нь хөгжмийн зохиолч ая зохиогч, 6 нь дууны үг зохиогч, 3 нь хөгжмийн нийтлэгч компани байна. Гишүүдийг сонгохдоо хөгжмийн урсгал жанр бүрээс төлөөлөл оруулахыг эрмэлзэнэ. (хүүхдийн, хипхоп, рок поп, альтернатив, мэргэжлийн хөгжим, кино дэлгэцийн бүтээл, нийтийн дууны, үндэсний хөгжим гэх мэт)
- 3.3.4. Нийгэмлэг нь хоёр зөвлөхтэй байж болох бөгөөд зөвлөхүүд нь бие даасан мэргэжлийн зөвлөх байна. Зөвлөхүүд нийгэмлэгийн үйл ажиллагааг явуулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, зохиогчийн эрхийн хууль бус үйлдэлтэй тэмцэх, Олон улсын зохиолч, хөгжмийн зохиолчдын нийгэмлэгүүдийн холбоо /CISAC/-д гишүүнээр ажиллахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх, Монгол улсын зохиогчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, дүрэм журмыг сайжруулах нөлөөллийн ажил явуулах зэргээр хамтран ажиллана.
- 3.3.5. Удирдах зөвлөлийн гишүүдийн үүрэг гүйцэтгэх сонгуульт хугацаа 4 жил байх ба Удирдах зөвлөлийн гишүүн ба дарга нэг удаа улиран сонгогдох эрхтэй.
- 3.3.6. Удирдах зөвлөлийн дарга ба гишүүн нь удирдах зөвлөлөөс сайн дураараа чөлөөлөгдөх хүсэлтээ Удирдах зөвлөлийн хуралд оруулж зөвлөлийн гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлүүлнэ.
- 3.3.7. Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- а/ Гүйцэтгэх албаны бүтэц зохион байгуулалт төсвийг батлах
 б/ Нийгэмлэгийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, биелэлтэнд хяналт тавих,
 в/ Нийгэмлэгийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар Гүйцэтгэх захирлын эрх, хэмжээг тогтоох Гүйцэтгэх захирлын эрх үүргийг тодорхойлох, Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулах
 г/ Гишүүний жилийн хураамж, элсэлтийн хураамжийн хэмжээ, бүтээл ашигласны төлбөрийн хэмжээ, лицензийн төлбөрийн хуваарилалтын журмыг хэлэлцэж батлах,
 д/ Нийгэмлэгт ирсэн хандив зээл тусламжийн зарцуулалт, нөөц сангийн зарцуулалтыг холбогдох журамд нийцүүлэн шийдвэрлэх,
 е/ Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлийн ажиллах журам, бусад холбогдох журмыг батлах;
 ё/ Нийгэмлэгийн нэр хүнд болон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

- 3.3.8. Удирдах зөвлөлийн хурлыг жилд 3-аас доошгүй удаа хийнэ.
- 3.3.9. Удирдах зөвлөлийн хурлын ирц 50-аас дээш хувь байвал хүчинтэйд тооцно.
- 3.3.10. Удирдах зөвлөлийн хурлын явцыг протоколд тэмдэглэх бөгөөд шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргаж, түүнд Удирдах зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурна. Удирдах зөвлөлийн хурлаас гаргасан шийдвэрийн талаар зарчмын өөр саналтай гишүүний тайлбарыг хурлын тэмдэглэлд хавсаргана.
- 3.3.11. Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр хувийн саналаар Удирдах зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж, орлогч гишүүдээс 30 хоногийн дотор нөхөн томилно.
 - а.Нас барсан;
 - б.Удирдах зөвлөлийн гишүүнийхээ үүргээ зохих ёсоор биелүүлээгүй;
 - в.Нийгэмлэгийн дүрэм, гишүүнчлэлийн гэрээгээ зөрчсөн
- 3.3.12. Удирдах зөвлөл ба гүйцэтгэх баг ажлын тайлангаа бүх гишүүдийн чуулганд тайлагнана.
- 3.3.13. Ерөнхий чуулганаар сонгогдсон 15 удирдах зөвлөлийн гишүүд дундаас ерөнхий чуулганд ирсэн нийт гишүүдийн олонхийн санал авсан зохиогч хүнээр удирдах зөвлөлийн даргыг сонгоно.

3.4. Удирдах зөвлөлийн дарга

- 3.4.1. Удирдах зөвлөлийн дарга нь нийгэмлэгийн тэргүүн байна.
- 3.4.2. Удирдах зөвлөлийн дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - а/ Нийгэмлэгийг гадаад дотоодод төлөөлөх,
 - б/ Нийгэмлэгийн үйл ажиллагаатай холбоотой бодлого боловсруулж, хэрэгжүүлэх,
 - в/ Удирдах зөвлөлийн хурал ба Ерөнхий чуулганыг хурлыг даргалах,
 - г/ Ерөнхий чуулган ба Бүх гишүүдийн хурлын тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах,
 - д/ Гүйцэтгэх захирлыг санал болгож, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах,
 - е/ Гүйцэтгэх захиралтай үр дүнгийн гэрээ байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, ажлын байрны тодорхойлолтыг батлах,
- 3.4.3. Удирдах зөвлөлийн даргын эзгүйд түүний санал болгосон Удирдах зөвлөлийн гишүүн орлоно.
- 3.4.4. Удирдах зөвлөлийн дарга орон гарсан тохиолдолд хамгийн ахмад гишүүн түр орлож, 60 хоногийн дотор Удирдах зөвлөлийн гишүүд дотроос даргыг санал болгож, бүх гишүүдийн хурлаар батламжилна.
- 3.4.5. Удирдах зөвлөлийн дарга гүйцэтгэх удирдлага байхыг хориглоно.

3.5. Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг

- 3.5.1. Нийгэмлэгийн Гүйцэтгэх захирал нь Удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд нийгэмлэгийн өдөр тутмын байнгын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 3.5.2. Гүйцэтгэх захирал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - а/ Удирдах зөвлөлөөс тогтоосон орон тоо, бүтэц, зохион байгуулалт, төсвийн хүрээнд ажлын албыг бүрдүүлж, түүнийг удирдах,
 - б/ Удирдах зөвлөлөөс тогтоож өгсөн эрх хэмжээний хүрээнд байгууллагын хөрөнгийг захиран зарцуулах,
 - в/ Нийгэмлэгийн стратеги, жил, улирлын үйл ажиллагааны төлөвлөгөө, орлого зардлын төсөв боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулан мөрдөх,
 - г/ Эрх зүйн харилцаанд байгууллагаа төлөөлөх
 - д/ Гишүүнээр элсэх хүсэлт гаргасан зохиогчидтой гэрээ байгуулж, бүтээлийн жагсаалтыг урын санд бүртгэх,
 - е/ Гишүүдийн бүтээлийг ашиглаж буй хувь хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан, тэднээс төлбөрийг авч, гишүүдэд хуваарилах, гэрээний гүйцэтгэлд хяналт тавих,
 - ё/ Бүтээл ашигласан төлбөрийг батлагдсан төсвийн дагуу энэхүү дүрэм, түүнтэй нийцүүлэн гаргасан журмын дагуу заагдсан үйл ажиллагаанд захиран зарцуулах,
 - ж/ Ажлын албаны ажил үүрэгтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг боловсруулж, батлуулж, мөрдүүлэх,
 - з/ Гүйцэтгэх захирал нийгэмлэгийг итгэмжлэлгүйгээр төлөөлнө.

- 3.5.3. Гүйцэтгэх захирал Удирдах зөвлөлд ажлаа тайлагнана.
- 3.5.4. Гүйцэтгэх захирал орон тооны байна.
- 3.5.5. Гүйцэтгэх захирлыг сонгон шалгаруулалтаар шалгаруулна.
- 3.5.6. Гүйцэтгэх албанд нийгэмлэгийн гишүүн ба түүний хамаарал бүхий этгээд ажиллаж болохгүй.

3.6. Хяналтын зөвлөл

- 3.6.1. Хяналтын зөвлөлд 1 мэргэшсэн нягтлан бодогч, 4 зохиогч гишүүнийг 4 жилийн хугацаатай сонгоно. Гишүүдийн 50 хүртэлх хувьтай тэнцэх орлогч гишүүнийг нэмж сонгож болно. Жинхэнэ гишүүн орон гарсан тохиолдолд орлогч гишүүн 30 хоногийн дотор нөхөн сонгогдно.
- 3.6.2 Хяналтын зөвлөлийн гишүүд хурлаараа мэргэшсэн нягтлан бодогч гишүүнээ сонгож, удирдах зөвлөлд мэдээлнэ.
- 3.6.3. Хяналтын зөвлөл нь дараах эрх, үүргийг хэрэгжүүлж, ажиллана.
 - а/ Бүх гишүүдийн хурал ба Ерөнхий чуулганы тогтоол шийдвэр, Удирдах зөвлөлийн бодлогын хэрэгжилтийн байнгын үйл ажиллагаанд хяналт тавих,
 - б/ Ажлын албаны лиценз эзэмшигчтэй байгуулж буй гэрээний нөхцөлд хяналт тавих,
 - в/ Эд хөрөнгийн ашиглалтад шалгалт хийх,
 - г/Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, төлбөр хуваарилалтын журмын биелэлтийг хянах
 - д/ Гишүүдийн бүтээл ашигласны төлбөртэй холбоотой гомдол, саналын дагуу шалгалт хийх
 - е/ Хяналтын зөвлөл ажиллах журмаа боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулна.
- 3.6.4. Хяналтын зөвлөл нь гүйцэтгэх ажлын албаны үйл ажиллагаанд жил бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр шалгалт хийнэ.
- 3.6.5. Хяналтын зөвлөл нь Бүх гишүүдийн хурал ба Ерөнхий чуулганд ажлаа тайлагнана.

Дөрөв. БҮТЭЭЛ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР ХУВААРИЛАХ

- 4.1. Бүтээл ашигласны төлбөрийн хэмжээ тарифын өөрчлөлт шинэчлэлтийг Бүх гишүүдийн хурлаар батална.
- 4.2. Бүтээл ашигласны лицензийн орлогыг Бүх гишүүдийн хурлаар баталсан Хуваарилалтын журмаар захиран зарцуулна.
- 4.3. Гүйцэтгэх захирал бүтээл ашигласны орлогоос 25 хүртэл хувиар суутган авч үйл ажиллагааны зардалд зарцуулна.
- 4.3. Нийгэмлэгийн санхүүгийн өмнөх жилийн нийт орлогын 5 хүртэлх хувиар жил бүр хуримтлал үүсгэж, бүтээл ашиглалттай холбоотой маргааныг шийдвэрлэх болон гарсан зайлшгүй зардлыг төлөх нөөц сан байгуулна.
- 4.4 Нөөц сангийн захиран зарцуулах журмыг бүтээл ашиглалтын төлбөр хуваарилах журамтай уялдуулан Удирдах зөвлөл боловсруулж, Удирдах зөвлөлийн хурлаар батлана.

Тав. НИЙГЭМЛЭГИЙН ӨМЧ ХӨРӨНГӨ, САНХҮҮЖИЛТ

- 5.1. Нийгэмлэгийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:
 - а/ Бүтээл ашигласны төлбөр лицензийн орлого
 - б/ Гишүүний татвар, элсэлтийн хураамж
 - в/ Гадаад, дотоодын байгууллага, иргэдийн хандив, зээл тусламж
 - г/ Төслийн үйл ажиллагааны орлого
 - д/ Дүрмийн зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагааны орлого
 - е/ Дүрмийн зорилгод нийцсэн бусад орлого
- 5.2. Нийгэмлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт шалгалтыг “Аудитын тухай” хуульд заасны дагуу хийлгэнэ.
- 5.3. Нийгэмлэг нь орлогоо Удирдах зөвлөлөөс баталсан санхүүгийн журмын дагуу нийгэмлэгийн дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулна.
- 5.4. Нийгэмлэг нь банкинд төгрөгийн болон гадаад валютын данстай байна.
- 5.5. Бүтээл ашигласны төлбөрийн хэмжээ, хуваарилалтын журмыг бүх гишүүдийн хурлаар батална.

5.6 Гадаад дотоодын байгууллага иргэдийн хандив, зээл тусламж, төрөөс олгосон санхүүжилтийн зарцуулалтыг удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

Зургаа. НИЙГЭМЛЭГИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

- 6.1. Нийгэмлэгийг өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэрийг 4 жилд 1 болох Ерөнхий чуулганы төлөөлөгчдийн гуравны хоёр хувийн саналаар хэлэлцэж, Монгол Улсын Иргэний хууль, Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ.
- 6.2. Нийгэмлэг хуулийн дагуу татан буугдсан тохиолдолд үл хөдлөх болон бусад өмч хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх, хэрэв тийм байгууллага байхгүй бол зорилгод нь нийцсэн үйл ажиллагаанд зарцуулахыг нийгэмлэгийн бүх гишүүдийн санал асуулгын үндсэн дээр Татан буулгах комисс шийдвэрлэнэ.
- 6.3. Нийгэмлэгийг татан буулгах тухай шийдвэрийг Ерөнхий чуулган гаргаснаас хойш 21 хоногийн дотор нийтэд мэдээлж, Улсын бүртгэлээс хасуулснаар тус нийгэмлэгийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцогдоно.